

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр

№ 25/52

Улаанбаатар хот

Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх, гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4 дэх заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зүгээс өөрийн зээлийн бүтээгдэхүүнүүдийн цар хүрээг тэлэх, харилцагчдынхаа өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангаж, санхүүгийн зах зээлд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татан төвлөрүүлэх үйл ажиллагааг 2023 оноос эхлэн хэрэгжүүлж буйг дурдсугай.
2. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд Компаниас дор дурдсан санал ирүүлсэнтэй танилцаад:
 - 2.1. Компани нь Олон улсад хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлдэг “DWM Asset Management” LLC-аар төлөөлүүлсэн DWM Income Funds S.C.A. SICAV-SIF, түүний дэд сан болох DWM SDGs Credit Fund (цаашид хамтад нь “**Санхүүжүүлэгч тал**” гэх)-аас нийт 2,500,000 ам.доллар хүртэлх үнийн дүн бүхий санхүүжилт (цаашид “**Санхүүжилт**” гэх)-ийг Зээлийн гэрээ (цаашид “**Зээлийн гэрээ**” гэх) байгуулах замаар татан төвлөрүүлэх тохиролцоонд хүрсэн болохыг тэмдэглэсүгэй.
 - 2.2. Компанийн зүгээс Зээлийн гэрээ байгуулах замаар Санхүүжилтийг хүлээн авах, улмаар Санхүүжилтийг үйл ажиллагаандаа ашиглаж, өөрийн зээлийн бүтээгдэхүүнүүдийн цар хүрээг тэлэх, харилцагчдын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах зорилгоо хэрэгжүүлэх үүднээс нийт 2,500,000 ам.долларын эхний санхүүжилтийг авах хүрээнд:
 - (a) Санхүүжүүлэгч талтай энэхүү тогтоолын Хавсралт 1А-д төслийг хавсаргасан Зээлийн гэрээг байгуулж, Зээлийн гэрээнд заасан нөхцөлийн дагуу Зээлдэгчийн үүрэг хүлээх;
 - (b) Санхүүжүүлэгч талтай энэхүү тогтоолын Хавсралт 1Б-д төслийг хавсаргасан Хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ байгуулж, Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах;(цаашид хамтад нь “**Гэрээний багц**”)

шаардлагатай байгааг тус тус тэмдэглэсүгэй.
3. Энэхүү тогтоолын 2.2-т заасан Гэрээний багцыг Санхүүжүүлэгч тал болон бусад холбогдох талуудтай байгуулж, хэрэгжүүлэх нь гагцхүү Компанийн ашиг сонирхлын төлөө бөгөөд Компанийн хөрөнгө оруулагчдын хувьд үр ашигтай шийдвэр мөн гэж дүгнэж буй тул Гэрээний багцыг байгуулахыг Компанид зөвшөөрсүгэй.

4. Зээлийн гэрээ болон түүний нөхцөлийг Хавсралт 1А-д заасан хувилбараар баталсугай.
5. Хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ болон түүний нөхцөлийг Хавсралт 1Б-д заасан хувилбараар баталсугай
6. Гэрээний багцад багтаж буй гэрээ, түүнчлэн эдгээртэй дагалдах бусад гэрээ, хэлцлийг холбогдох талуудтай эцэслэн тохиролцож байгуулах, Багц гэрээний дагуу аливаа баримт бичиг үйлдэх, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулах, эдгээртэй холбогдох шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
7. Гэрээний багцыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус багцад багтаж буй аливаа гэрээ, хэлцэлд дурдсан зөвшөөрөл, хүсэлт, мэдэгдэл болон үүгээр хязгаарлагдахгүйгээр Компанийн нэрийн өмнөөс үйлдвэл зохих аливаа баримт бичгийг үйлдэх, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулан холбогдох талд хүргүүлэх, хариу хүлээн авах зэрэг бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
8. Гэрээний багц түүнтэй холбогдуулан үйлдсэн аливаа баримт бичгийн хэрэгжилт, Санхүүжилт татан төвлөрүүлэлт болон ашиглалт, холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр

№ 25/53

Улаанбаатар хот

Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх, гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4 дэх заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зүгээс өөрийн зээлийн бүтээгдэхүүнүүдийн цар хүрээг тэлэх, харилцагчдынхаа өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангаж, санхүүгийн зах зээлд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татан төвлөрүүлэх үйл ажиллагааг 2023 оноос эхлэн хэрэгжүүлж буйг дурдсугай.
2. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд Компаниас дор дурдсан санал ирүүлсэнтэй танилцаад:
 - 2.1. Компани нь Олон улсад хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлдэг “DWM Asset Management” LLC, түүний DWM Income Funds S.C.A. SICAV-SIF (цаашид “**Санхүүжүүлэгч тал**” гэх) сан, уг санд эрх олгосон Monega Multi-Sector Microfinance & Impact Loan Fund болон Monega Mikrofinanz & Impact Fonds (цаашид хамтад нь “**Эрх шилжүүлэгч**” гэх)-аас нийт 1,750,000 ам.доллар хүртэлх үнийн дүн бүхий санхүүжилт (цаашид “**Санхүүжилт**” гэх)-ийг Зээлийн гэрээ (цаашид “**Зээлийн гэрээ**” гэх) байгуулах замаар татан төвлөрүүлэх тохиролцоонд хүрсэн болохыг тэмдэглэсүгэй.
 - 2.2. Компанийн зүгээс Зээлийн гэрээ байгуулах замаар Санхүүжилтийг хүлээн авах, улмаар Санхүүжилтийг үйл ажиллагаандаа ашиглаж, өөрийн зээлийн бүтээгдэхүүнүүдийн цар хүрээг тэлэх, харилцагчдын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах зорилгоо хэрэгжүүлэх үүднээс нийт 1,750,000 ам.долларын эхний санхүүжилтийг авах хүрээнд:
 - (a) Санхүүжүүлэгч талтай энэхүү тогтоолын Хавсралт 1А-д төслийг хавсаргасан Зээлийн гэрээг байгуулж, Зээлийн гэрээнд заасан нөхцөлийн дагуу Зээлдэгчийн үүрэг хүлээх;
 - (b) Санхүүжүүлэгч талтай энэхүү тогтоолын Хавсралт 1Б болон Хавсралт 1В-д төслийг хавсаргасан Хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ байгуулж, Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах;(цаашид хамтад нь “**Гэрээний багц**”)
шаардлагатай байгааг тус тус тэмдэглэсүгэй.
3. Энэхүү тогтоолын 2.2-т заасан Гэрээний багцыг Санхүүжүүлэгч тал болон бусад холбогдох талуудтай байгуулж, хэрэгжүүлэх нь гагцхүү Компанийн ашиг сонирхлын төлөө бөгөөд Компанийн хөрөнгө оруулагчдын хувьд үр ашигтай

шийдвэр мөн гэж дүгнэж буй тул Гэрээний багцыг байгуулахыг Компанид зөвшөөрсүгэй.

4. Зээлийн гэрээ болон түүний нөхцөлийг Хавсралт 1А-д заасан хувилбараар баталсугай.
5. Хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээнүүд болон түүний нөхцөлийг Хавсралт 1Б болон Хавсралт 1В -д заасан хувилбараар баталсугай
6. Гэрээний багцад багтаж буй гэрээ, түүнчлэн эдгээртэй дагалдах бусад гэрээ, хэлцлийг холбогдох талуудтай эцэслэн тохиролцож байгуулах, Багц гэрээний дагуу аливаа баримт бичиг үйлдэх, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулах, эдгээртэй холбогдох шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
7. Гэрээний багцыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус багцад багтаж буй аливаа гэрээ, хэлцэлд дурдсан зөвшөөрөл, хүсэлт, мэдэгдэл болон үүгээр хязгаарлагдахгүйгээр Компанийн нэрийн өмнөөс үйлдвэл зохих аливаа баримт бичгийг үйлдэх, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулан холбогдох талд хүргүүлэх, хариу хүлээн авах зэрэг бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
8. Гэрээний багц түүнтэй холбогдуулан үйлдсэн аливаа баримт бичгийн хэрэгжилт, Санхүүжилт татан төвлөрүүлэлт болон ашиглалт, холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

